

“АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

“Алтанбулаг” чөлөөт бүсэд 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нийт 30 ААН-ийн 25 дэлгүүр, 2 цайны газар, кофе шоп, 1 гэр амралт үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээр нь дэлхийн 19 улсаас хүнсний бараа, техник, тоног, төхөөрөмж, гэр ахуйн бараа, гоо сайхны бараа, спорт бараа, бэлэн хувцас зэрэг 200 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулж байна.

Улмаар хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааны цар хүрээ өсөн нэмэгдэхийн сацуу барилга, байгууламжуудаа барьж буй ААН-ийн тоо өссөөр байна. Өнөөгийн байдлаар 20 ААН барилгын ажлаа эхлэн хөрөнгө оруулалтаа хийж байна.

